

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 30

№ 24/03/01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан,  
болон санхүүгийн тайлан, төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалт, Тооллогын комиссын дүнг  
үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ :**

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Компанийн 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсугай.
3. Хурлаас баталсан төсөл, төлөвлөгөө, дүгнэлт, шийдвэрийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 30

№ 24/03/02

Улаанбаатар хот

**Компани ногдол ашиг хувиарлахгүй тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2024 оны 4-р сарын 30 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсаныг мэдэгдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 30

№ 24/03/03

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 17, 62 дугаар зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа болон андеррайтерийн үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Дээрх тусгай зөвшөөрлүүдийг нэмж авч байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг гаргах хувьцааны тоо хэмжээгээр нэмэгдүүлсүгэй.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
4. Хөрөнгө оруулалтын зөвлөх, дилер, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, андеррайтерийн эрхийг нэмж авч байгаа тул холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
6. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Г.ОЮУНБОЛД**

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 30

№ 24/03/04

Улаанбаатар хот

**НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ, ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ**  
**ЭСЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.3, 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрх болон Андеррайтерийн тусгай зөвшөөрөл нэмж авах гэж байгаа тул компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг гурван тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гарган нэмэгдүүлсүгэй.
2. Нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

**ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 53, 54-р зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2024 оны 4-р сарын 30 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.
2. Нэмж хувьцаа гаргах болон компани хуваах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
3. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53-р зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

**ХУРЛЫН ДАРГА**



**Г.ОЮУНБОЛД**

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ УЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4-р сарын 30

№ 24/03/06

Улаанбаатар хот

**ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХОЛЫН**  
**ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76, 89, 92- р зүйлүүд, 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь цаашид дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрх, андеррайтерийн эрхийг нэмж авах гэж байгаатай холбогдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зэрэг ажилд бусадтай их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Уг хэлцэлд хяналт тавьж холбогдох эрх бүхий байгууллагууд, хувьцаа эзэмшигчдэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД